# ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН
# 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **ЗОРИЛТ 1. “ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛНА” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1.<br>Их дунд эрсдэлтэй үнэлэгдсэн болон шинээр байгуулагдсан 19 обьектод төлөвлөгөөт шалгалт хийнэ. | Обьектийн хамралт | 70% | - 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтанд 19 обьектийг хамруулахаар төлөвлөсөн, обьектийн хамралт 100%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>- Шалгалтын мөрөөр танилцуулга үйлдэн илэрсэн алдаа дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 235 заалттай 18 албан шаардлагаар үүрэг өгч гүйцэтгэлийн хяналт шалгалтанд 11 байгууллагыг хамруулж бусад байгууллагад албан шаардлагын биелэлт ирүүлсэн албан бичгээр үнэлэхэд хэрэгжилт 77.4 % байна. | 100% |
| | | Эрсдлийн түвшин | | 4 төрлийн хяналтын хуудсаар хяналт шалгалтыг хийж эрсдэлийн түвшинг үнэлэхэд:<br>- 3 байгууллага буюу 15.7 хувь нь “бага” эрсдэлтэй;<br>- 16 байгууллага буюу 84.2 хувь нь “дунд” эрсдэлтэй тус тус үнэлэгдлээ. | |
| 2 | Арга хэмжээ 1.2.<br>Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах | Зөрчил арилгуулалтын хувь | 70% | Энэ чиглэлээр СХГ-аас удирдамж ирээгүй бөгөөд Газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу баяр наадам болон цаг үеийн шаардлагаар 2 удаагийн хяналт шалгалтыг ХХАА-н газрын хяналтын улсын байцаагч, ЭМГ-ын эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн нартай хамтран нийтийн хоол үйлдвэрлэлийн газар, хуушуурын цэгүүд зэрэг обьектуудад хяналтыг хийж гарч болзошгүй эрсдэлээс сэргийлж мэргэжил арга зүйн зөвлөгөө | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | болон зөвлөмжүүдийг өгч ажилласан. | |
| 3 | Арга хэмжээ 1.3.<br>Эмнэлзүйн лабораторид урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Обьектийн хамралтын хувь | 80% | - ЭМЯ-ны СХГ-аас ирүүлсэн “Эмнэлзүйн лабораторийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 10-00/12 дугаартай удирдамжаар шалгалтыг явуулсан.<br>- Шалгалтанд бие даан үйл ажиллагаа явуулдаг 1 лаборатори, эмгэг судлалын шинжилгээ хийдэг НЭ-ийн лаборатори зэрэг обьектууд хамрагдсан. Шалгалтын мөрөөр албан шаардлага үйлдэгдээгүй.<br>- Обьектийн хамралт 100%<br>- Шалгалтын дүнг танилцуулгаар нэгтгэн 2024 оны 06 сарын 04-ний өдрийн 03/512 тоот албан бичгээр Салбарын хяналтын газарт хүргүүлсэн. | 100% |
| | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | 92% | | |
| 4 | Арга хэмжээ 1.4.<br>Өрхийн эрүүл мэндийн төвд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Обьектийн хамралтын хувь | 100% | - ЭМЯ-ны СХГ-аас ирүүлсэн “Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 10-00/16 дугаартай удирдамжаар Ар Мөнхжин, Ар Мөнгөнчагнуур өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хамруулсан.<br>- Обьектийн хамралт 100%<br>- Илэрсэн алдаа дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 17 заалттай 2 албан шаардлагыг хүргүүлж хэрэгжилтийг тооцоход биелэлт 75.6% байна.<br>- Шалгалтын дүнг танилцуулгаар нэгтгэн 2024 оны 05 сарын 20-ны өдрийн 02/403 тоот албан бичгээр Салбарын хяналтын газарт хүргүүлсэн. | 100% |
| | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | 75% | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ 1.5.<br>Шүдний тусламж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Обьектийн хамралтын хувь | 100% | - ЭМЯ-ны СХГ-аас ирүүлсэн "Шүдний эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 10-00/13 дугаартай удирдамжаар Тод смайл, Болор талст дент, Гэгээн үйлс, Тана Арцат, Булган Дент зэрэг 5 байгууллагыг хамруулсан.<br>- Обьектийн хамралт 100%<br>- Илэрсэн алдаа дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 33 заалттай 4 албан шаардлагыг хүргүүлж хэрэгжилтийг тооцоход биелэлт 86% байна.<br>- Шалгалтын дүнг танилцуулгаар нэгтгэн 2024 оны 10 сарын 04-ний өдрийн 03/819 тоот албан бичгээр Салбарын хяналтын газарт хүргүүлсэн. | |
| | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | 85% | | |
| 6 | Арга хэмжээ 1.5.<br>Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь | 100% | Тайлант хугацаанд иргэний гомдол 1, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар 1, байгууллагын хүсэлт 1 нийт 3 удаагийн төлөвлөгөөт бус шалгалт хийгдсэн. Үүнд:<br>Нэг._Архангай аймгийн Засаг даргын тамгын газрын 04/412 тоот албан бичгээр "Иргэд олон нийттэй харилцах 70331111" утсанд хандаж ирүүлсэн иргэн С.Ууганбатын гомдол:<br>- 2024 оны 04 сарын 02-ны өдрийн "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 10-14/01 дугаартай удирдамжаар Цэнхэр сумын эрүүл мэндийн төвийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан шалгалтыг хийж тусламж үйлчилгээтэй холбогдол бүхий алдаа дутагдлыг илрүүлэн холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэлийн арга хэмжээ тооцуулан илэрсэн алдаа дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 6 заалт бүхий 1 албан шаардлагыг хүргүүлсэн, шаардлагын хариуг хуулийн хугацаанд ирүүлсэн, биелэлт 90.6% -тай байна.<br>Хоёр. Газрын даргын өгсөн үүрэг даалгавар.<br>- 2024 оны 04 сарын 26-ны өдрийн "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 10-14/02 дугаартай удирдамжаар Хашаат сумын эрүүл | 100% |
| | | Зөрчил арилгалтын хувь | 92% | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | мэндийн төвийн хүүхдэд үзүүлсэн тусламж үйлчилгээний байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчилд 2412000425 дугаартай Зөрчлийн хэрэг үүсгэн 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сахилгын шийтгэл ногдууллаа.<br>Гурав. Архангай аймгийн Төрийн банкны захирал Э-ээс ирүүлсэн хүсэлт.<br>- 2024 оны 11 сарын 18-ний өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 10-14/03 дугаартай удирдамжаар эмнэлгийн магадлагаа олголтын байдалд Ар-Мөнхжин, Ар-Манал өрхийн эмнэлгийн холбогдох эмч эмнэлгийн ажилтнуудыг хамруулан хийж улсын байцаагчийн 10-14-01/068/02 дугаартай дүгнэлтийг үйлдэн хариуг хүргүүлсэн. Илэрсэн алдаа дутагдлын мөрөөр улсын байцаагчийн 6 заалт бүхий 2 албан шаардлагаар үүрэг өгч ажиллаа. | |
| 7 | Арга хэмжээ 1.7.<br>Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх | Албан шаардлагын биелэлт хувь<br><br>Зөрчил арилгалтын хувь | 83%<br><br>68% | - Албан шаардлагын хариу ирүүлэлт нийт 19 байгууллагад 89%.<br>- Гүйцэтгэлийн хяналт шалгалтанд хамрагдсан 11 буюу 73%.<br>- Зөрчил арилгалт 74%. | 78% |
| **ЗОРИЛТ 2. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | |
| 6 | Арга хэмжээ 2.1.<br>“Архив бичиг хэрэг хөтлөлтийн тухай” хууль, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо, хариу өгсөн албан бичгийн тоо, архивт хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо | Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна. | - Ирсэн өргөдөл гомдол 1: “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 10-14/01 дугаартай удирдамжийг Газрын даргаар батлуулан хяналт шалгалтыг хийж холбогдох арга хэмжээг хуулийн хугацаанд авч хэрэгжүүлсэн<br>- Хүлээн авсан албан бичиг 23, хариу өгвөл зохих албан бичиг 12, хариу өгсөн 12.<br>- 2023 оны хяналт шалгалтын баримт бичгийг товъёоглон үдэж 3 хавтас бүхий баримт бичгийг архивт хүлээлгэн өгсөн. | 100% |
| 7 | Арга хэмжээ 2.2.<br>Удирдлагын болон дотоодын шуурхай | Тухайн жилд өгсөн үүрэг даалгаврын | 100% | Дотоодын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг тухайн хугацаанд нь биелүүлэн | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллана. | биелэлтийн хувь | | ажилласан. | |
| 8 | Арга хэмжээ 2.3. Байгууллагын удирдлагаас цохогдсон хугацаатай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн ажиллана. | Хугацаатай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь | 100% | Тайлант хугацаанд удирдлагаас нийт 18 албан бичиг цохогдсон, түүний 12 албан бичиг хугацаатай байсныг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. | 100% |

**ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Эрүүл мэндийн чиглэлээр шинээр гарсан хууль тогтоомж, тушаал, шийдвэр, дүрэм журмыг судалж хяналт шалгалтын үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлж ажиллана. | Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг судалсан байна. | Шинээр гарсан дүрэм журмыг судалж хяналт шалгалтын ажилд мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллана. | Тайлант хугацаанд 2024 онд шинээр гарсан ЭМС-ын 2024 оны "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" А/112 тоот тушаалыг эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг шалгахад хэрэгжүүлэн мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Мөн “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг хангуулахаар шалгалтанд хамрагдсан нийт байгууллагуудад шалгуураар үнэлж мэргэжил арга зүйн зөвлөгөөг газар дээр нь өгч ажилласан. | 100% |
| 10 | Арга хэмжээ 2.2. Улсын байцаагчдад зориулсан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана. | Сургалтад оролцсон байна. | Оролцсон сургалтын тоо | СХГ-аас онлайнаар зохион байгуулагдсан 3 удаагийн, танхимын 1 нийт 4 удаагийн сургалтанд тус тус оролцсон. Үүнд:<br>Нэг. “2024 оны төлөвлөлт анхаарах асуудлууд” онлайн сургалт -2024.02.14<br>Хоёр. “Эрүүл мэндийн салбарын улсын байцаагчдийн зөвлөгөөн” танхимын сургалт 2024.05.09-10<br>Гурав. “Шилэн хяналт” онлайн сургалт-2024.05.24<br>Дөрөв. “Эмнэлгийн тусламж үйлчилгээнд анхаарах асуудлууд” онлайн сургалт-2024.11.19 | 100% |
| 11 | Арга хэмжээ 2.3. Улсын байцаагчдад зохион байгуулах “Зөрчлийн хэрэг бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой сургалт”-нд оролцоно. | Сургалтад оролцсон байна. | Зөрчлийн хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаа сайжирсан | СХГ-аас зохион байгуулагдсан 2024 оны 05 сарын 09-10-ий өдрүүдэд зохион байгуулагдсан “Эрүүл мэндийн салбарын улсын байцаагчдийн зөвлөгөөн” сургалтаар “Зөрчлийн хэрэг бүртгэлийн үйл ажиллагаа”-тай холбоотой сургалт хийгдсэн, түүнийг хяналт шалгалтын ажилдаа хэрэгжүүлэн | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байна. | ажилласан.<br>Аймгийн Прокурорын газраас зохион байгуулагдсан “Зөрчлийн бүртгэл, мэдээлийн сан” сэдэвт сургалтанд 2024 оны 12 сарын 17-ны өдөр оролцсон. | |
| 12 | Арга хэмжээ 2.4.<br>Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан байна. | Сургалтын тоо | Тайланд хугацаанд энэ чиглэлийн сургалт төлөвлөгдөөгүй байна. | - |

ТАЙЛАН ГАРГАСАН:

| | | |
|---|---|---|
| Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч | ................................. / М.ЦАГААНДАЛАЙ/ | 2024 оны ... дугаар сарын ... |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |